

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, аймгийн Засаг даргаас 11 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулж, 6 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

2023 оны 03 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд Алсын Хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат “Шинэ Сэргэлтийн Бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт сургалтыг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Ерөнхий сайдын ажлын алба, Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан. Сургалтад нийт 39 төрийн байгууллагын 100 албан хаагч хамрагдсан.

Төрийн албаны ерөнхий шалгалт 03 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулагдаж, нийт 58 иргэн шалгалт өгснөөс, 23 иргэн буюу тэнцсэн.

Монгол цэргийн өдөр, Орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ойг угтан Цэргийн штаб, Онцгой байдлын газар хамтран марш тактикийн аварга тасаг шалгаруулах тэмцээнийг 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр зохион байгууллаа. Тус тэмцээнд 4 байгууллагын 7 тасгийн алба хаагч оролцсон.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллаж байна.

2023 оны 03 дугаар сарын нийт татварын орлогын төлөвлөгөө 2 317 270 мян төгрөг, гүйцэтгэлээр 2 222 124 мян төгрөг буюу 95.8 хувь, үүнээс улсын төсвийн орлогын төлөвлөгөө 379 063 төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 520 852 мян төгрөг буюу 137 хувь, сумын төсвийн орлогын төлөвлөгөө 1 582 220 мян төгрөг төвлөрүүлэхээс 1 373 856 мян төгрөг буюу 86.8 хувь, аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 735 050 мян төгрөг төвлөрүүлэхээс 387 416 мян төгрөг буюу 52.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 700 хуулийн этгээд бүртгэлтэй байна. Үүнд: ХК 1, ХХК 365, ББН 5, ЗБН 9, Хоршоо 31, ХЗХоршоо 1, ОНӨҮГ 6, Салбар 66, төсөвт болон төрийн бус байгууллага, сан ОНБ 216 байна.

Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр:

Баянтал сумын 4-р цэцэрлэгийн 2018-2021 оны санхүүгийн баримтанд Авлигатай тэмцэх газрын төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж 18 971,3 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, хуулийн байгууллагад шилжүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 425 дугаар нээлттэй хорих ангид хоригдож байгаа хоригдлуудын 2022 оны цалин хөлсөд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийлээ. Шалгалтаар нийт 1 352,0 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлж, 552.0 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт үйлдсэн. Үүнээс: 440.0 мянган төгрөгийг нөхөн олгуулахаар, 112.0 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгож, 800.0 мянган төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, нийт 43 байгууллагын шилэн дансанд хяналт тавьсан. 1, 2 дугаар сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдал 95.4 хувьтай байна. Энэ нь өмнөх сараас 9.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цахим хуудас болон фейсбүүк хуудас, Хууль Эрх зүйн хэлтсийн фейсбүүк хуудсаар дамжуулан “Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай, Авлигын эсрэг” хуулиар постер бэлтгэж олон нийтэд мэдээлэл өгч ажилласан.

Төрийн архив: Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 2 хөмрөгийн 11 хадгаламжийн нэгж, 696 хуудас, 322 заалт, 1833 хүний нэр, 378 байгууллагын нэр, 1339 газар зүйн нэр, 462 хуудас баримтыг программд холбож ажилласан. 2023 оны 3 дугаар сард 25 иргэнд архивын лавлагаа хуулбар гаргаж үйлчилгээ үзүүлсэн.

Улсын бүртгэлийн чиглэлээр:

Улсын бүртгэлийн хэлтсээс тайлант сард дараах чиглэлээр нийт 691 иргэнд төрийн үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд:

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан-144
- Иргэний үнэмлэх шинээр олгосон-51
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо-32
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо-5
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо-1
- Үрчлэлтийн бүртгэлийн тоо-1
- Нас барсныг бүртгүүлсэн тоо-7
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн - 28
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо-16
- Тоон гарын үсэг олголт-35

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл-2
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл-15
- Гэрээний бүртгэл-37
- Барьцааны гэрээний бүртгэл-96
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга - 8

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл-5
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт-13

Архивын чиглэлээр:

- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар-37
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар-156

Хууль сахиулах чиглэлээр: “Гэмт хэрэг зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах” журамд заасны дагуу 2023 оны тайлант сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 86 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн 15, зөрчлийн 71 гомдол мэдээлэл байна. Зөрчил үйлдсэн 22 иргэнийг эрх бүхий албан тушаалтнаас болон шүүхээс 4 404,500 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 5 хүнийг эрүүлжүүлж, 10 хүнийг шүүхээр баривчлуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 19 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан байна.

03 дугаар сард гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг цахим хэлбэрээр олон нийтэд хүргэх, хууль сурталчилах, ухуулах, цаг үеийн болон нөхцөл байдлын талаарх мэдээ мэдээллийг түгээх ажлыг тасралтгүй зохион байгуулж, төв, орон нутгийн холбогдох

байгууллагаас цахим орчинд нийтэлсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх санамж, анхааруулга, зөвлөмж 12, видео шторк 14, бусад төрлийн 5, нийт 31 мэдээллийг "Говьсүмбэр аймаг дахь Цагдаагийн хэлтэс" пэйж хуудсанд байршуулж, иргэд, олон нийтэд түгээж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан.

Шүүхийн шинжилгээний хэлтэс нь: Хэргийн газрын үзлэгт 11 удаа оролцсоноос хүний амь нас хохирсон 1, зам тээврийн ослын 1, хулгайлах гэмт хэрэг 1, бусад 8 байна. Хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 240 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

Онцгой байдлын газар нь: 2023 онд зохион байгуулах Гамшгаас хамгаалах ангиллын сургалт нэгдсэн төлөвлөгөөний хүрээнд Газар хөдлөлт, Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах аргачлал, гамшгийн үед хэрхэн ажиллах тухай анхан шатны ойлголт, галын аюулгүй байдлын тухай ойлголт, гал унтраах дадлага сургууль, "what3words" программыг ашиглах талаарх сургалтыг Политехникийн коллежийн оюутан, суралцагчдад 2 удаа, Тэс петролиум шатахуун түгээх станц, Нэгдсэн эмнэлэгийн ажилтан албан хаагчдад зохион байгуулсан. Тус сургалтанд нийт 3 байгууллагын 168 оюутан, сурагч, ажилтан алба хаагчдад сургалт зохион байгуулсан.

"Олон Улсын иргэний хамгаалалтын өдөр"-ийг тохиолдуулан тус аймгийн Онцгой байдлын газар Улаан загалмайн хороотой хамтран аймгийн Засаг даргын Тамгын газар, Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын 1, 2, 5 дугаар сургуулиудад "Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа"-ны талаарх арга хэмжээг зохион байгуулж, иргэдэд мэдээ, мэдээлэл өгч ажилласан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь: 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж буй "Дүрэмт хувцас бидний бахархал-Дүрмээр өмсөх нь бидний үүрэг" аяныг зохион байгуулсан.

Тайлант хугацаанд "Үндсэн хууль", "Эрүүгийн хууль" "Зөрчлийн тухай хууль", "Хорих ангийн дотоод журам", "Хяналтын хуудас хэрэглэх журам", "Аюулгүйн тойрог тогтоох журам", "Дасан зохицох чадвар суулгах", "Харилцаанд үүсэх зөрчил", "Биеэ авч явах байдал", "Хандлагаа өөрчлөх нь" зэрэг 12 сэдвээр 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан.

Политехникийн коллежтэй хамтран хүнд машин механизмын засварчин мэргэжлээр 15 хүмүүжигч, гагнуурчин мэргэжлээр 15 хүмүүжигч, авто машины засварчин мэргэжлээр 15 хүмүүжигчийг тус тус хамруулсан.

ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр: Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн мэдлэг чадварын явцын үнэлгээний даалгавар дээр анализ хийж, даалгаврын хүнд хөнгөн зэргийг тодорхойлон, цаашид даалгавар болгох арга зүйг хэрхэн сайжруулах талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Сургуулийн өмнөх боловсролын 3 дугаар сарын статистик мэдээгээр хамран сургалт 93.6 хувьтай /1775 хамрагдахаас 1663 хүүхэд/ байна.

Ерөнхий боловсролын сургуулийн менежментийг сайжруулах жилийн ажлын хүрээнд Баянтал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль, Сүмбэр сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль дээр зөвлөх үйлчилгээ үзүүллээ.

2023 оны улсын төрөлжсөн олимпиадын 2-ын давааг 13 төрлийн 46 ангилалд зохион байгуулж, 400 сурагч, багш хамрагдлаа.

Элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэх, түүний явцыг дүгнэн цаашид анхаарах асуудлаа тодруулах зорилгоор "Сорилго-1" шалгалтыг зохион байгуулаа. Энэ хичээлийн жилд суралцаж төгсөх 12 дугаар ангийн нийт 189 сурагч шалгалтад хамрагдлаа.

Англи хэлний багш нарыг чадавхжуулах "Pearson" хөтөлбөр хэрэгжиж аймгийн хэмжээнд 9 багш одоогийн байдлаар 100 хувь хамрагдаж байна.

Хүүхдийн хоолны чанарыг сайжруулах, аюулгүй, шим тэжээлтэй хоол хүнсээр ханган ажиллах улирлын онцлогт тохирсон цэс гарган ажиллуулах зорилгоор аймгийн хэмжээний 5 цэцэрлэгийн гал тогооны хүнсний хангамж хадгалалт, хуурай хүнсний агуулах, хадгалалтад хяналт тавьж, зөвлөмж, зөвлөгөөг өгсөн.

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуулийн 7 болон 14 дүгээр заалтын дагуу ерөнхий боловсролын 1,2,4,5 дугаар сургууль болон Политехникийн коллежийн ундны усны шүүлтүүр, цэвэршүүлэгчийг тоолж, суралцагчийн тоонд хүрэлцэж байгаа эсэхэд үнэлгээ хийж, ус цэвэршүүлэгчийн тоог нэмэх, ундны усанд шүүлтүүр байрлуулах талаар зөвлөмж өгч ажиллалаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр: Политехникийн коллежийн оюутнуудад “ХҮҮХДИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ОРОЛЦОО” сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд 12 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийт 196 оюутан хамрагдсан.

Гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа хүүхдийг эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөллөөс хөндийрүүлэх, хууль зөрчөн хүүхдэд сургалт, хүмүүжлийн арга хэмжээ үзүүлэх зэрэг үйлчилгээ үзүүлдэг аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр хуралдаж, 2023 онд хийж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталсан.

Биеийн тамир, спортын чиглэлээр: Монголын хүүхдийн спортын VII наадмын анхан шатны аймгийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн 2023 оны 03 дугаар сарын 4, 5-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, нийт 27 багийн 220 гаруй өсвөрийн тамирчид оролцсон.

Жүдо бөхийн спортыг хөгжүүлэх, аймгийн өсвөрийн багийн байнгын бэлтгэл сургуулилтыг хангах, бүс болон улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдыг сонгон шалгаруулах тэмцээнийг 2023 оны 03 дугаар сарын 10,11-ний өдөр зохион байгуулж, нийт 6 багийн 130 өсвөрийн тамирчид хурд хүч авхаалж самбаагаа сорин оролцлоо.

Монголын хөл бөмбөгийн холбооны 21 аймгийн "Хөвгүүдийн цом-2023" тэмцээний U-14 ангилалд Б.Батжавхлан дасгалжуулагчтай Говьсүмбэр аймгийн баг мөнгөн медаль хүртсэн.

Монголын Хүүхдийн спортын наадамд оролцох эрх авах Жүдо бөхийн өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 3-р сарын 4, 5-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, 160 гаруй тамирчид оролцож, аймгийн баг тамирчид багийн дүнгээр 3-р байрт шалгарсан.

Дартсын "Хобби" холбооноос 2023 оны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, ганцаарчилсан эмэгтэй ангилалд 9 тамирчин, ганцаарчилсан эрэгтэй ангилалд 16 тамирчин, 50 наснаас дээш ахмадын төрөлд 18 тамирчин, багийн төрөлд 10 баг тус тус оролцлоо.

Хэнтий аймгийн Чингис хотод 2023 оны 03 дугаар сарын 17-19 хооронд зохион байгуулагдсан волейболын идэрчүүдийн U-18 насны зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд зүүн 5-н аймгийн хөвгүүдийн 8, охидын 6 нийт 14 багийн 168 тамирчид өрсөлдлөө. Тус тэмцээнд аймгийн Засаг даргын дэргэдэх волейболын өсвөрийн шигшээ багийн тамирчид оролцож, хөвгүүдийн баг хүрэл медаль хүртэн Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх авч, охидын баг 4 дүгээр байр эзэлсэн байна.

Соёл, урлагийн чиглэлээр: Юнескогоос тунхагласан “Дэлхийн яруу найргийн өдөр”-ийг жил бүрийн 3 дугаар сарын 21-ний өдөр тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд аймгийн Нийтийн номын сан, Монголын Зохиолчдын Эвлэлийн Говьсүмбэр аймаг дахь “Утга зохиолын төлөө” хүндэт шагналт “Боржигидай сэцэн” салбартай хамтран “Найргийн зөн” яруу найргийн өдөрлөгийг зохион байгуулсан.

2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Зүүн Чойр хийд орчмын түүх, соёлын үл хөдлөх дурсгалд судалгаа, хадгалалт хамгаалалтад нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж үр дүнг нь тайлагнан ажиллалаа.

Монголын хүүхдийн шилдэг зохиол бүтээлийг хүүхэд багачуудад таниулах, сурталчлах, тэдний дунд уран уншлагын урлагийг хөгжүүлэх зорилготой Монголын хүүхдийн ордноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Төрийн соёрхолт, Урлагийн гавьяат зүтгэлтэн нэрт

хүүхдийн зохиолч Жамбын Дашдондог агсны нэрэмжит “Уран жиргээ 2023” аймгийн уралдааныг Соёл, урлагийн газартай хамтран зохион байгууллаа. Тус уралдаанд цэцэрлэгийн насны 13, сургуулийн насны 40, нийт 53 хүүхэд оролцсон.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Үзүүлэлт	2022 оны 03 сар	2023 оны 03 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	76	65
Гэрийн төрөлт	0	1
Амьд төрсөн хүүхэд	75	65
Амьгүй төрөлт	1	0
Нас баралт	27	15
Эмнэлгийн нас баралт	5	6
Хоног болоогүй нас баралт	3	1
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	0
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	0
Эмнэлгээс гарсан хүний тоо	2188	1148
Амбулаторийн үзлэг	27705	21668
Халдварт өвчин	2196	24

Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Энэ жилдээ - Эрүүл жиндээ” аянд нэгдэж нээлтийн үйл ажиллагаа зохион байгууллаа.

“Дэлхий сүрьеэтэй тэмцэх өдөр”-өөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 425 дугаар нээлттэй хорих ангийн алба хаагчдад “Сүрьеэгийн далд халдвар, эмчилгээ, хяналт”, “Сүрьеэ өвчний халдвар хяналт, сэргийлэлт”-ын талаар сургалт зохион байгууллаа. Мөн сүрьеэгийн тархвар судлалын асуумж бөглөх, туберкулины сорил тавьж, далд халдварын эмчилгээнд хамруулах үзлэг хийсэн.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр: Ажил хайгчаар бүртгэлтэй 12 иргэнийг ажлын байранд зуучилж, ажил орлоготой болгосон. Өссөн дүнгээр 39 иргэнийг ажилд зуучилсан. Зуучлагдсан иргэдийн мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан И-жоб платформд бүртгэсэн. Ажил хайгч 21 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгсөн.

2019-2022 онд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 149 иргэний эргэн төлөлтөд хяналт тавьж, тайлант хугацаанд 61 иргэний 11421,0 мян төгрөгийг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” санд төвлөрүүлэн ажилласан. Өссөн дүнгээр 36,283,800 төгрөгийг төвлөрүүлээд байна.

Жижиг зээл арга хэмжээний хүрээнд 10 зээл хүсэгчийн 280000,0 мян.төг бүхий зээл хүссэн төслийг хүлээн аваад байна.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Сумдын өвс тэжээлийн аюулгүйн нөөц задарч, малчдад хөнгөлөлттэй үнээр борлуулсан. Улсын нөөцийн салбараас 1 малчин өрхөд 30 хүртэл боодол өвсийг өгөхөөр тооцож, 1 боодол өвсийг 10500 төгрөгөөр, 1 шуудай хивгийг 16500 төгрөгөөр олгож байна.

2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар нийт төллөвөл зохих 190161 эх малаас 4287 эх мал төллөж,, 4315 төл гарсан. Үүнээс бойжиж байгаа төл 4315, төллөлт 2.3 хувь, төл бойжилт 100 хувь, төлийн хорогдолгүй, том малын хорогдол 257 буюу оны эхний нийт малын 0.06 хувийг эзлэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан

зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам” болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын “Хөнгөлөлттэй зээлийн ерөнхий нөхцөл батлах тухай” А/37 дугаар тушаалын дагуу Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2023 онд олгох хөнгөлөлттэй зээлийн төсөл хүлээн авах үйл ажиллагаа 2023 оны 02 дугаар 9-ний өдрөөс эхлэн цахим системээр дамжуулан 30 хоногийн хугацаанд цахимаар хүлээн авах ажлын хүрээнд мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулман. Үүнд:

Зээлийн батлан даалтын сантай хамтран 2023 оны 3 дугаар сарын 7-нд орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчид, арилжааны банкуудын зээлийн эдийн засагч нарт тус тусад нь “Зээлийн батлан даалтын үйл ажиллагаа, батлан даалт гаргах журам”-ын талаар сургалтыг зохион байгуулав. Тус сургалтад орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгч 39 иргэн, аж ахуй нэгж, 3 банкны захирал, зээлийн мэргэжилтэн 19 төлөөлөл хамрагдсан.

Хүнсний нөөц: Хүнсний нөөцийн бодит мэдээллийг 3 сумаас авч нэгтгэв. Үүнд:

Аймгийн дүнгээр мах 45 тн буюу 20 өдөр, гурил 40 тн буюу 45 өдрийн, сүү 3 тн буюу 1 өдрийн, төрөл бүрийн будаа 17 тн буюу 25 өдрийн, төмс 14 тн буюу 11 өдрийн, хүнсний ногоо 12 тн буюу 5 өдрийн, элсэн чихэр 6 тн буюу 15 өдрийн, давс 5 тн буюу 18 өдрийн, савласан ус 17 тн буюу 1 өдрийн, өндөг 1.6 тн буюу 11 өдрийн, ургамлын тос 4.2 тн буюу 18 хоногийн нөөцтэй байна.

Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2023 оны 03-р сарын үнийн мэдээ:

Зах зээлд худалдаалагдаж буй зарим хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ өнгөрсөн сараас 10-2000 төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал: үхрийн мах /ястай, цул/ 2000 төгрөгөөр, хонины мах /ястай, цул/ 1000-1500 төгрөгөөр, адууны мах 1000 төгрөгөөр, ямааны мах /ястай, цул/ 1500 төгрөгөөр, лууван 200 төгрөгөөр, төмс 100 төгрөгөөр, гурил /алтан тариа 1кг/ 100 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

Үнийн мэдээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дотооддоо үйлдвэрлэж буй үхрийн мах 1000 төгрөгөөр, хонины мах 500 төгрөгөөр, төмс 300 төгрөгөөр, хүнсний ногоо 50-200 төгрөгөөр, гурил 100-200 төгрөгөөр өссөн бол бол импортын бүтээгдэхүүн болох элсэн чихэр 400 төгрөгөөр, цагаан будаа 350 төгрөгөөр, ургамлын тос 1550 төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

№	Бараа бүтээгдэхүүн	Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан	
1	Үхрийн мах	Ястай	12000	12000	+2000
		Цул	15000	14000	+2000
2	Хонины мах	Ястай	9000	8500	+1000
		Цул	12000	12000	+1500
3	Адууны мах	Ястай	9000	8500	+1000
		Цул	9500	9000	
4	Ямааны мах	Ястай	8500	7500	+1500
		цул	11000	9500	+1500
5	Тахианы мах	Гуя	12000	10500	
		мөч	14300	11000	
6	Лууван	монгол	2500	2000	+200
		хятад			
7	төмс	монгол	1700	1400	+100
		хятад			
8	Байцаа	монгол	2100	2000	
		хятад			
9	чинжүү	монгол			
		хятад	10000	8700	-

10	Манжин	монгол	2400	2000	
		хятад			
11	Сонгино бөөрөнхий	Монгол	3000	2800	-
		Хятад			
12	Помидор	монгол	-	-	
13	Өргөст хэмх	монгол	11000	10000	
14	Элсэн чихэр	монгол	3500	3200	
15	Будаа	Цагаан задгай кг	4000	3500	
		Шар слава кг	5100	3000	
		Гурвалжин будаа кг	6000	4000	
16	Сүү	Задгай	3000	2800	
		Сүү ХХК 0,5л			
		Сүү ХХК 1л	4300	4000	
17	Тараг	Задгай	3500	3000	
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	5500	4200	
18	Талх	Чойр талх	2000	1950	
19	Өндөг	ОХУ	550	500	+10
		Монгол	580	500	+10
20	Алтан тарианы гурил	Задгай дээд	1500	1300	
		Задгай 1-р зэрэг	2400	2000	+100
		Задгай 2-р зэрэг	1400	1000	
		Савласан д/дээд /	2700	2500	
		Савласан дээд	2200	1800	
		Савласан 1-р зэрэг	1950	1400	
		Савласан 2-р зэрэг	1200	1000	
21	Ургамлын тос	Олейна	10800	10500	
		Алтан	8000	7500	
22	Гоймон	Алейка	2000	2000	
		А/тариа савхан	1700	1500	

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчны чиглэлээр: “Эрүүл аюулгүй- Цэвэр орчин” бүрдүүлэх арга хэмжээний тухай 2023 оны 02 албан даалгаврын хүрээнд аймгийн хэмжээнд төлөвлөгөө дагуу улсын чанартай авто зам дагуух мал амьтны сэг зэм болон хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэх, сумын төвд нийтийн цэвэрлэгээ хийх зэрэг ажлуудыг сум тус бүр зохион байгуулсан. Үүнд:

Сүмбэр суманд байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээ, цаашдын хамтын ажиллагаа, анхаарах асуудал сэдвээр уулзалт хийсэн. Уулзалтын үр дүнд хог хаягдлыг бууруулах, цэвэр, аюулгүй орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бодит арга хэмжээ төлөвлөж, хамтран ажиллах гурвалсан гэрээ байгуулсан.

Ерөнхий боловсролын сурагчдад хог хаягдлыг ангилан ялгаж хэвшүүлэх, гэр бүлийнхэндээ үлгэр жишээ үзүүлэх, бусдад нөлөөлөх, ангилсан хогоо дахиварт тушаах, хог хаягдлын хор уршиг, түүнийг багасгах арга замд сургах зорилгоор Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Зөв дадал, эерэг өөрчлөлт- Ногоон ирээдүй” сэдэвт хаврын аян зарласан.

Аймгийн Аялал жуулчлалын холбоотой хамтран “Аялал жуулчлалын салбарт зочлох үйлчилгээний байгууллагын хамтын ажиллагаа” сэдэвт зөвлөлдөх уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтад 20 хүн хамрагдаж, 2023 онд аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах чиглэл, цаашид анхаарах асуудал, хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталлаа.

Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас WELCOME TO MONGOLIA самбарыг аймаг бүрт орох гарах төв зам дагуу болон угтах, үдэх хаалганы орчимд самбарт байрлуулах үүрэг өгсний дагуу самбарыг байрлуулсан.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар Шивээговь сумын Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/19 дүгээр захирамжийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг цахимаар 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр газрын цахим бирж болох www.mle.mn хаягаар 1 байршилд дуудлага худалдааг зохион байгуулан ажилласан. Үүний үр дүнд “Превалент” ХХК нь 164'0 сая төгрөгийн үнийн санал ирүүлж дуудлага худалдааны ялагчаар тодорсон.

Мөн Сүмбэр сумын Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/51, А/52 дугаар захирамжаар 10 байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг зарлаж, зар мэдээг зууны мэдээ сонин болон www.mle.mn сайт, байгууллагын цахим сайтад байршуулаад байна.

Худалдан авах ажиллагааны талаар: Төсвийн ерөнхийлөн захирагчид 2023 онд нийт 7,613,397.1 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 24 бараа, ажил, үйлчилгээ худалдан авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 4,109,800,0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл арга хэмжээ, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 921,869,4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 төсөл арга хэмжээ, Аймгийн “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр 1,972,409,3 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 15 төсөл арга хэмжээ, аймгийн “Авто замын сан”-ийн хөрөнгөөр 440,616.5 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ажил, Аймгийн “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал”-аар 28,702.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ажил төлөвлөөд байна.

Баянтал сум: 2023 оны 03 дугаар сарын 6-ны өдөр Сумын Эмэгтэйчүүдийн зөвлөл баярын цэнгүүн зохион байгуулж, 154 иргэн хамрагдлаа.

2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр сумын Эрүүл мэндийн төвөөс сумын иргэддээ урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлгийн шинжилгээ, витаминжуулах ажлыг зохион байгууллаа. Үзлэгт 72 иргэн хамрагдсан.

Энэ хавар өөрийн сумын 88 малчин, 72 мал бүхий өрхийн 72035, гадны отрын 1540, нийт 73575 толгой мал хаваржиж байна. Нийт 29020 мал төллөхөөс 03 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 7244 мал төллөж, унага 17, тугал 96, хурга 5731, ишиг 1400 толгой, нийт 7314 төл хүлээн авсан. Мал төллөлт 24.9 хувь, төл бойжилт 100 хувьтай байна. Том малын хорогдол 39 байгаа нь нийт малын 0.05 хувь болж байна.

Сүмбэр сум: Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд багийн Засаг даргын тодорхойлолтыг 210 иргэнд, хөнгөлөлт тусламж 21 иргэнд хүргэж, ХАӨМС-ын программын өрхийн алдааг засан, шинээр төрсөн хүүхэд болон нас барсан, шилжиж ирсэн, шилжиж явсан хүмүүсийн мэдээллийг программд тухай бүр бүртгэж, хасалт хийсэн.

Сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор “НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ”-ийг 03 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан. Уг арга хэмжээнд аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс оролцож, иргэдэд ОНХС-аар 2022 онд хийгдсэн ажил, E-Mongolia гар утсан дээрээ хэрхэн ашиглах, өөрийн өмчлөлийн газраа хэрхэн шалгах талаар зааварчилгаа, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, аюул, осол, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа, таниулга хийж, гарын авлага тараан, 161 иргэнд төрийн үйлчилгээ үзүүлсэн.

Шивээговь сум: 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдөр “Дархан цаазат газар, түүнийг хамгаалах нь” сургалтад сумын төсвийн байгууллагын албан хаагчдыг хамруулсан. Тус сургалтад 13 албан хаагч хамрагдсан.

Хүнс хөдөө аж ахуйн яамнаас жижиг дунд үйлдвэрлэлийн зээл сонирхсон иргэн, аж ахуй нэгж, байгууллагад зориулсан сургалтанд 5 иргэн, зээлийн батлан даалтын сангийн сургалтанд 7 иргэнийг хамруулсан.

Сумын Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/28 дугаар захирамжийн дагуу 2023 оны 03 дугаар сарын 02, 03-ны өдрүүдэд сэг зэм устгалын ажлыг зохион байгуулсан.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР